



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/219

Есенбулаг сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/100 дугаар тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам", Зам тээврийн сайд, Сангийн сайдын хамтран баталсан 2026 оны А/47 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх "Ногоон хот-Тогтвортой хөгжлийн дэд бүтцийн төсөл багц-2 (Баруун бүс, Говь-Алтай аймаг)" төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх Говь-Алтай аймгийн Ногоон хот-Тогтвортой хөгжлийн дэд бүтцийн төсөл Хүлэмж байгуулах, усалгааны худаг гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Амгаланбаатар (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:	3.Жаргалтуяа	(Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
	Ч.Ууганбаяр	(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсон)
	Ц.Зоригт	(Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл) (тохиролцсон)


Нарийн бичиг:

Б.Эрхбаяр

(Худалдан авах
ажиллагааны газрын
худалдан авах ажиллагаа
хариуцсан ахлах
мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Ж.Амгаланбаатар)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

